

**МИК ХОЛДИНГ ХК БОЛОН ТҮҮНИЙ
ОХИН КОМПАНИУД**
(Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

**Нэгтгэсэн Санхүүгийн Хураангуй Тайлан
2024 оны 12 дугаар сарын 31**



НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

МИК Холдинг ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байдлын хураангуй тайлан болон тухайн жилийн нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлангаас бүрдсэн Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг МИК Холдинг ХК болон охин компаниуд (“Групп”)–ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “Тайлан бэлтгэх үндэслэл” тодруулгад тайлбарласны дагуу Группын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байна.

Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)–ын шаардсан бүх тодруулгыг агуулаагүй болно. Иймд энэхүү нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан ба аудиторын дүгнэлт нь Группын аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлтийг орлохгүй.

Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлт

Бид 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад зөрчилгүй дүгнэлт өгсөн ба уг дүгнэлтэнд Аудитын онцгойлсон асуудлууд багтсан. Аудитын онцгойлсон асуудал нь тухайн жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудал болох “Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт” байсан.

Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг “Тайлан бэлтгэх үндэслэл” тодруулгад тайлбарласны дагуу бэлтгэх нь Группын удирдлагын хариуцлага юм.

Аудиторын хариуцлага

Бидний үүрэг бол шинэчлэгдсэн Аудитын олон улсын стандарт (“АОУС”) 810 буюу “Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлангийн талаар дүгнэлт өгөх гэрээт ажил”–ын дагуу шаардсан горимуудыг гүйцэтгэж, түүндээ үндэслэн нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланд дүгнэлт өгөх явдал юм.

Ernst & Young Mongolia Audit LLC

ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид ХХК



ДОРЖБАТЫН МАНДАХБАЯР
Партнер

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2025 оны 3 дугаар сарын 18

МИК ХОЛДИНГ ХК БА ОХИН КОМПАНИУД

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлант жилийн

Нэгтгэсэн Ашиг Алдагдал ба Бусад Дэлгэрэнгүй Орлогын Хураангуй Тайлан

	2024 MNT'000	2023 MNT'000
Хүү болон түүнтэй адилтгах орлого	385,014,458	372,691,947
Хүүний зардал	(333,987,188)	(289,467,241)
Хүүний цэвэр орлого	51,027,270	83,224,706
Шимтгэл, хураамжийн зардал	(19,290,395)	(17,949,733)
Нийт үйл ажиллагааны орлого	31,736,875	65,274,973
Хүлээгдэж буй үнэ цэнийн бууралтын алдагдлын буцаалт/(зардал)	(2,615,084)	624,992
Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгийн цэвэр олз/(гарз)	(1,928,346)	1,245,099
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн цэвэр олз/(гарз)	1,070,924	(8,038,358)
Нийт үйл ажиллагааны ашиг	28,264,369	59,106,706
Үйл ажиллагааны зардал	(19,666,830)	(17,188,289)
Бусад орлого/(зардал), цэвэр	(38,611,293)	2,764,812
Татварын өмнөх ашиг/(алдагдал)	(30,013,754)	44,683,229
Орлогын албан татварын зардал	(7,040,581)	(16,569,573)
Нийт дэлгэрэнгүй орлого/(алдагдал)-ыг илэрхийлэх тайлант жилийн ашиг/(алдагдал)	(37,054,335)	28,113,656
Нэгж хувьцаанд ногдох ашиг/(алдагдал) (төгрөгөөр)		
Нэгж хувьцаанд ногдох суурь болон шингэрүүлсэн ашиг/(алдагдал)	(2,430.29)	1,843.89

Тайлан бэлтгэх үндэслэл. Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Группийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан болон Нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.

МИК ХОЛДИНГ ХК БА ОХИН КОМПАНИУД

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлант жилийн

Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Хураангуй Тайлан

	2024 мян.төг	2023 мян.төг
ХӨРӨНГӨ		
Бэлэн мөнгө ба банкн дахь харилцах, хадгаламж	212,851,957	343,498,698
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн хэрэглүүр	288,307,003	131,545,865
Буцаах нөхцөлтэй орон сууцны зээлийн багцын авлага	228,500,361	203,662,983
Буцаах нөхцөлтэй зээлийн багцын авлага	40,695,387	23,905,581
Худалдан авсан орон сууцны зээлийн багцын авлага	4,121,074,245	4,082,796,161
Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгө	128,172,138	137,673,182
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	1,950,282	152,847,243
Бусад хөрөнгө	51,461,130	59,365,821
Үндсэн хөрөнгө	33,153,766	34,800,079
Биет бус хөрөнгө	904,474	260,948
Урьдчилж төлсөн орлогын албан татвар	230,790	190,620
Хойшлогдсон татварын хөрөнгө	100,135	9,619,187
НИЙТ ХӨРӨНГӨ	5,107,401,668	5,180,166,368
ӨР ТӨЛБӨР		
Бусад өр төлбөр	23,551,682	18,241,664
Зээлээр авсан эх үүсвэр	24,382,523	9,577,148
Өрийн үнэт цаас	726,128,478	760,736,859
Баталгаажсан бонд	4,308,848,566	4,317,570,902
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	39,915	-
Орлогын албан татварын өглөг	1,849,203	1,976,169
Хойшлогдсон татварын өр	21,391,844	33,799,834
НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,106,192,211	5,141,902,576
ЭЗДИЙН ӨМЧ		
Энгийн хувьцаа	20,709,320	20,709,320
Нэмэгдэж төлөгдсөн капитал	52,225,115	52,225,115
Халаасны хувьцаа	(62,143,136)	(62,143,136)
Нөөц	(9,581,842)	27,472,493
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ	1,209,457	38,263,792
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	5,107,401,668	5,180,166,368

Тайлан бэлтгэх үндэслэл. Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг СТОУС-ын дагуу бэлтгэсэн Группийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан болон Нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангуудыг өөрчлөлгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.